



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан¹)

ТЭЭВРИЙН АЧААНЫ МАШИНААС ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НЭВТЭРСНИЙ ХУРААМЖ АВСАН НЬ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГА, ЗОРИЛГО, ХҮРЭЭНД НИЙЦЭЭГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/0068

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр

Шийдвэрийн төрөл: Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч хуулийн этгээдүүдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд (хуучин нэрээр) 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/71 дүгээр тушаалын хавсралтаар Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг 3.5 тн-оос дээш бодит жинтэй ачааны машин нэвтрэхэд **50,000 төгрөг** байхаар тогтоосон. Тухайн хураамжийг хүчингүй болгуулахаар холбогдох хуулийн этгээдүүдээс шүүхэд хандсан ба 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхээс 001/ХТ2024/0083 дугаар тогтоолоор² уг хураамж ямар зорилгоор батлагдсан, хэнд үйлчлэх нь тодорхойгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2³-т заасан шаардлагыг хангаагүй гэж дүгнэн, маргаан бүхий тушаалын холбогдох заалтыг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн байдаг.

Гэсэн хэдий ч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд (өөрчлөгдсөн нэрээр)-аас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/844 дүгээр тушаалын хавсралтаар хураамжийн хэмжээг шинэчлэн батлахдаа **урьдын адил 50,000 төгрөг** байхаар тогтоосон байна. Иймд нэхэмжлэгчдийн зүгээс хариуцагч нь "... Улсын дээд шүүхийн 2024 оны 001/ХТ2024/0083 дугаар тогтоолд заасан нөхцөл байдлыг арилгалгүйгээр хураамжийг дахин хэвээр баталсан, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2-т заасныг хангаагүй ..." гэж маргажээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3412?daterange=2025-09-09%20-%202025-09-09&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2026.02.11).

² Улсын дээд шүүхийн 2024 оны 09 сарын 23-ны өдрийн 001/ХТ2024/0083 тогтоол, https://shuukh.mn/single_case/3279?daterange=2024-09-01%20-%202024-09-30&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2026.02.11).

³ Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 60 дугаар зүйлийн 60.1 "Захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна:", 60.1.2 "тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх".



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Давж заалдах шатны шүүхээс:** Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг тогтоохдоо холбогдох судалгаа, нөлөөллийн шинжилгээг хийж Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн ** дугаарт нийтэлсэн байна.
2. Нэхэмжлэгч нар “...аялал жуулчлалын зорилгогүй буюу орон нутгийн чанартай авто замаар тээвэр хийж буй этгээдэд үйлчлэхгүй болохыг тодорхой заах шаардлагатай гэж заасныг зөрчиж хууль зөрчсөн зохицуулалтаа дахин хэвээр баталсан ... тушаалын холбогдох хэсэг нь нэхэмжлэгч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна” гэж тайлбарладаг.
3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8-д зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийг тогтоосон нь Говийн бага Дархан цаазат газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт хамаарч байна.
4. Олон улсын ачаа тээврийн буюу нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлж байгаа төлөв байдлын шинжилгээгээр агаар дахь хүхэрлэг хий болон тоосонцрын агууламж ихээр дэгдэж байгаа нь Тусгай хамгаалалттай газар нутагт байх иргэд, мал амьтан, байгальд сөргөөр нөлөөлж байгаа нь тогтоогдож байх тул Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн унаган төрхөөр нь хадгалах, иргэд болон байгаль, ан амьтны эрх, ашгийг хамгаалах, Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг буюу байгаль хамгаалагч нарын ажиллах нөхцөл зэргийг сайжруулан санхүүжүүлэх хөрөнгийг бий болгох зорилгоор уг хураамжийг хураан авч байгааг буруутгах үндэслэлгүй.
5. **Нэхэмжлэгч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлын үндэслэл:** Нүүрсний тээврийн үйл ажиллагаа эрхлэгч компаниуд уг газраар дайран өнгөрөхдөө төрийн байгууллагаас аливаа төрлийн үйлчилгээ авдаггүй. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 6/6 дугаар тогтоолын дагуу тогтмол төлдөг. Бид шороон бус хатуу хучилттай замыг ашиглан үйл ажиллагаа эрхэлснээр үүсэж болох тоосжилтыг бууруулж байна гэж үзэж байна.
6. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.36-д зааснаар “... агаар, ус, хөрс ашигласны, бохирдуулсны ... төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төлбөр” гэх бөгөөд уг харилцааг тусгайлсан хуулиар буюу Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар зохицуулах учиртай бөгөөд энэ тохиолдолд хэм хэмжээний давхардал үүсэж байгааг хариуцагчаас судлаагүй байна. Нэхэмжлэгч нь авто тээврийн албан татвар, авто зам ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг, мөн тусгай хамгаалалттай газар нутагт нэвтэрсний хураамжийг жолооч тус бүрээр төлдөг.



7. **Хяналтын шатны шүүхээс:** Улсын дээд шүүхийн 2024 оны 001/ХТ2024/0083 дугаар тогтоолд “**тухайн хураамж нь аялал жуулчлалын зорилгогүй буюу улс, орон нутгийн чанартай авто замаар тээвэр хийж буй этгээдэд үйлчлэхгүй болохыг тодорхойлон заах шаардлагатай**” талаар тусгасан байхад хариуцагчаас нөлөөллийн шинжилгээ хийхдээ ачаа авто замын тээврийн бодит нөхцөл, хураамжийн зорилго, үндэслэлийг тодорхой уялдаатайгаар тусгаагүй байна. (14)⁴
8. Нэхэмжлэгч хуулийн этгээдүүд говийн бага дархан цаазат газраар дамжин өнгөрөхөөс өөр сонголтгүй буюу тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрч буй нь **аялал жуулчлалын зорилгогүй нь илэрхий**, мөн төрөөс тогтоосон маршрутын дагуу **тусгай хамгаалалттай газар нутгаар дайран өнгөрөхдөө хууль тогтоомжид заасан аливаа үйлчилгээг тухайн бүс нутгийн төрийн захиргааны байгууллагаас аваагүй**, энэ талаарх нэхэмжлэгч хуулийн этгээдүүдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбарууд нь үндэслэл бүхий байна. (15)
9. Хэдийгээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8, 27 дугаар зүйлийн 18-д зааснаар тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт нь нэвтрэх хураамж хамаарахаар хуульчилсан боловч хариуцагчаас тус тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх **хураамжийн хэмжээг тогтоохдоо хуулийн агуулга, зорилго, үйлчлэх хүрээг хэм хэмжээний актад тодорхойлон тусгаж, ялгамжтай байдлаар зохицуулаагүй** ... (16)
10. Нэхэмжлэгч хуулийн этгээдүүдээс нүүрс тээвэрлэх үйл ажиллагаа явуулахдаа тухайн дайран өнгөрч буй бус нутагт хамаарах **авто зам, агаар, ус, хөрсийг ашиглаж, бохирдуулсны төлбөр болон хог хаягдлын төлбөрийг тухайлсан холбогдох хууль, журмын дагуу төлдөг талаар хяналтын шатны шүүх хуралдаанд тайлбарласан** бөгөөд энэ тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.40-д заасан “хураамж” буюу тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийг төлөх хуулийн нөхцөл үүсээгүй байхад хариуцагчаас маргаан бүхий хэм хэмжээний актын холбогдох хэсэгт заасан хураамжийг төлөхөөр тогтоосон нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцээгүй гэж үзэхээр байна. (17)
11. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг тогтоох шийдвэрийг дахин гаргахад тусгах асуудлын талаар Улсын дээд шүүхийн 2024 оны 001/ХТ2024/0083 дугаар тогтоолд тодорхой заасан байхад хариуцагч захиргааны байгууллагаас дахин хэм хэмжээний актыг гаргахдаа уг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй нөхцөл байдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс харгалзан дүгнэлт өгч, хэргийг шийдвэрлээгүй байна. (19)

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



12. Дээрх үндэслэлээр хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч хуулийн этгээдүүдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

---o0o---